



# МАХ ИМПЭКС ХК-ийн 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



# АГУУЛГА



Компанийн товч танилцуулга



Онцлох үйл явдлууд



Бизнесийн үйл ажиллагаа



Санхүүгийн үзүүлэлт



Компанийн хэтийн төлөв

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



## Эрхэм зорилго

Бид дэвшилтэт техник тохнологийг ашиглан Эрүүл мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж, хэрэглэгчдээ дээдэлсэн, салбартаа манлайлагч нь байна.

## Алсын хараа

Чанар стандартаар тэргүүлсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг компани болох.

## Уриа үг

Эрүүл махан бүтээгдэхүүн **ЭХ ОРНЫ БАЯЛАГ**

# КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



1946 онд нийслэл хотыг мах, махан бүтээгдэхүүнээр хангах чиг үүрэгтэй “**Боловсон мах комбинат**” нэртэйгээр байгуулагдаж 74 дэх жилдээ ажиллаж байгаа хүнсний ууган үйлдвэр юм.



# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



## Үйлдвэрийн хүчин /өдөрт/

Бог 8000 толгой нядлах

Бод 800 толгой, 300 гахай төхөөрөх

340 тн тураг мах, дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр

Гүн хөлдөөх

16 000 тн тураг мах хадгалах зоориудтай

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



- Компани нь хотын төмөр замын сүлжээнд мал, түүхий эд, бараа материалын болон мах бэлэн бүтээгдэхүүн ачиж, буулгах зориулалтын хэд хэдэн салаа замуудаар холбогдсон, үйлдвэрлэлийг тасралтгүй хэвийн явуулах эрчим хүч, ус, дулаан хангамжийн найдвартай эх үүсвэр бүхий төвлөрсөн системд холбогдсон.
- Хэрэглэгчдэд нийлүүлж буй бүтээгдэхүүнд стандарт аргачлалын дагуу өдөр тутам шинжилгээ хийж, дүнг үндэслэн чанарын баталгаа олгохын зэрэгцээ үйлдвэрлэлийн орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд микробиологийн шинжилгээ хийж, байнгын хяналт тавьж ажилладаг тул манай компанийн бүтээгдэхүүн нь чанарын баталгаатай, эрүүл ахуйн хувьд найдвартай тооцогддог.

# ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД



- НИЙСЛЭЛ ХОТЫНХОО ХҮН АМЫГ МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР хангаж байгаа
- Монгол малын махыг дэлхий нийтэд таниулах онцгой үүрэг гүйцэтгэж Ази, Европ, Ойрхи Дорнодын орнуудад мах, махан бүтээгдэхүүн экспортлож арвин туршлага хуримтлуулсан байна
- Инновацийн хөгжлийн хүрээнд 2000 оноос үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор ХБНГУ-ын "Multivac", "Textor" брендийн бүрэн ажиллагаатай автомат машин суурилуулан, Европын техник, технологийг үйлдвэртээ бүрэн нэвтрүүлэн техник, технологийн иж бүрэн шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байдаг.
- ISO9001:2008 олон улсын чанарын удирдлагын систем нэвтрүүлж, салбартаа анхдагч болсон

# ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУД



Мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх орчин үеийн техник технологитой танилцуулахаар махны үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж технологийн дэлхийн чиг хандлагыг тодорхойлдог гурван жилд нэг удаа ХБНГУ-ын Франкфурт хотод зохиогддог Олон улсын нэр хүндтэй IFFA үзэсгэлэнд сүүлийн 3 удаа тогтмол оролцож байна.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж байгаа томоохон хөтөлбөрүүдийн нэг болох 2016 онд эхэлсэн **“Малчдыг дэмжих хөтөлбөр”**-ийг үргэлжлүүлэн тайлант онд хөдөө орон нутагт баг томилон ажиллуулж эхэлсэн.





Малчдыг дэмжих хөтөлбөрийг 2016 оноос жил бүр зохион байгуулдаг болсон

## Хөтөлбөрийн давуу тал

- Малчид найдвартэй бэлэн мөнгөөр мал, махаа нийлүүлнэ.
- Нийслэлчүүдийн мах, махан бүтээгдэхүүн баталгаажна.
- Экспорт хийх бодит гарц нэмэгдсэн
- Махны үнийг тогтоворжуулна.
- Малчин хүссэн үедээ эрүүл ахуйн цэвэр орчинд үйлдвэрийн аргаар хамгийн хямд үнээр төхөөрүүлэх
- Малыг зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлүүлэх
- Графикт хугацаанд ус , өвсөөр хангуулж тусгай зориулалтын малын хашаанд байрлуулна.
- Малчдын махыг бусад худалдан авагчдад зуучлуулан борлуулах

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Малчдыг дэмжих хөтөлбөрөөр



ЭРҮҮЛ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

1946  
ОНООС



2016 онд 950 тонн



2017 онд 1500 тонн



2018 онд 1600 тонн мах



2019 онд 2600 тонн мах

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Мах импэкс ХК-ийн ТУЗ-өөс 2019 онд хийсэн ажлын тайлангийн хурлаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийж компанийн хэмжээнд бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөн ажиллаж байна.

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийслэл хотын амын 2020 оны хаврын улирлын хүсний хэрэгцээнд зориулан нөөцийн махыг худалдаанд гаргаж эхэлсэн.



2020.03.11-2020.06.30

СБД, ЧД, СХдүүргийн 35  
дэлгүүрээр

772 тонн мах



# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Иргэдийн дунд махны амт, чанарт сэтгэгдэл өндөр, эрэлт ихтэй байсан тул Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2019 оны А/309 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан ажлын хэсэгтэй хамтран нөөцийн махны өргөтгөсөн худалдааг зохион байгуулж ажилласан.

Өртгөтгөсөн худалдаагаар 138 тонн мах борлуулсан.



# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дэлхий нийтийг хамарсан хөл хорионоос шалтгаалан махны экспортыг хязгаарласан тул махан бүтээгдэхүүн, хонь, адууны махны үйлдвэрлэл тодорхой хувиар буурч махны экспорт хэсэг хугацаанд тасалдсан.

Засгийн газраас арга хэмжээ авсны үр дүнд одоогоор адууны мах, дулааны аргаар боловсруулсан махыг экспортолж байгааг албаныхан хэлж байгаа боловч цар тахалтай холбоотойгоор зарим нэг хүндрэл гарч тайлант хугацаанд 50 тонн адууны махыг БНХАУ руу экспортолсон байна.

# COVID 19 цар тахлын үед гарсан Хүндрэлүүд



Махны экспорт зогссон

- ▶ Төлөвлөгөөт ашиг орлого 1.5 дахин буурсан.
- ▶ Зарим хийгдэх хөрөнгө оруулалт болон засвар үйлчилгээний ажлууд хойшилсон.
- ▶ Сул зогсолтууд үүссэн . /Нийт ажилчдын 10% -15%/

Дотоодын зах зээл дэх махны борлуулалтын ашиг буурсан

Түрээсийн орлого буурсан

# COVID 19 цар тахлын үед авсан арга ХЭМЖЭЭНҮҮД



Ажлын байрыг авч үлдэх

Сул зогсолттой ажилтнуудыг цалитай амраах

0-6 насны хүүхэдтэй эхчүүдийг цалинтай амраах,  
гэрээсээ ажлаа хийх


7 хоног бүр нийт ажилчдад амин дэмийн дэмжих  
мөнгөн тэтгэмж

Аарц, аньс, чацарганы шүүсийг өдөр бүр ажлын байранд  
2-3 удаа уулгах


Дархлаагаа дэмжээрэй аян (мах, гурил, гоймон)

Ариун цэвэр хөдөлмөр хамгаалалын зардлыг хэвийн  
нэмсэн






Тайлант хугацаанд компанийн техник зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:



Цахилгаан цех, дахин дамжуулах подстанцын дээврийг шинэчлэх ажилд 72 сая төгрөг зарцуулсан.



Мах ангилан боловсруулах үйл ажиллагаанд зориулан БНХАУ-ын Hebei Xiaojin компаниас 50.3 сая төгрөгийн махны машин худалдан авав.



Мах хадгалах зоориудын дулаан алдагдлыг бууруулснаар хүйтэн үйлдвэрлэлд зарцуулах хөрөнгө багасна. Үүний тулд хийт 5 зоорины 7 хаалгыг шинээр хийж суурилуулахад 4,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.



Хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд 16 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аммиакын болон усны насосуудыг худалдан авч суурилуулсан, 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ОХУ-аас хөргөлтийн шингэн болон аммиагыг импортлон оруулж ирсэн байна.

Мах боловсруулах үйлдвэрийн шуллаганы цехэд нерж тэрэг, гулууз мах зөөвөрлөх тэрэг шинээр нэмж хийсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайнаар амжилттай зохион байгуулсан.

Махны үнийн хөөрөгдлийг тогтворжуулж ажилласан

Улс оронд оруулж байгаа хувь нэмэр \*



# 2019-2020 онд бэлтгэсэн махны тооцоо



№	Махны төрөл	ТОО ХЭМЖЭЭ (тн)	НЭГЖ ҮНЭ (₮)	НИЙТ ҮНЭ (мян.төг-өөр)
1	Үхэр	561	6970	3,910,170.00
2	Хонь	792	5650	4,474,800.00
3	Ямаа	483	5350	2,584,050.00
4	Адуу мах	70	5860	410,200.00
5	Дайвар бүтээгдэхүүн			452,635.00
6	Бусад			232,456.00
	<b>ДҮН</b>	<b>1906</b>		<b>12,064,311.00</b>

**Нийт махны 762,4 тн буюу 40 хувь үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн**


# Санхүү үйл ажиллагааны талаар



## МАХНЫ БОРЛУУЛАЛТЫН ЗАДАРГАА

Экспортод	тн	70	3.7%
Улсын нөөцөд	тн	910	47.7%
Дотоодын	тн	810	42.5%
Бусад	тн	116	6.1%
<b>Нийт</b>		<b>1906</b>	<b>100%</b>


## БОРЛУУЛАЛТАД ЭЗЛЭХ ХУВЬ



# Борлуулалт (нэр төрлөөр)



Борлуулалтад эзлэх хувь /үнийн дүн мян.төг-өөр/



# БОРЛУУЛАЛТЫН ХАРЬЦАА



№	Үзүүлэлт	2019	2020	өөрчлөлт	хувиар
1	Нийт орлого	12,792,674.40	14,508,289.10	1,715,614.70	13.4%
2	Нийт зардал	12,209,638.70	14,801,599.00	2,591,960.30	21.2%
3	Цэвэр ашиг	583,035.70	(293,309.90)	(876,345.60)	-150.3%

# КОМПАНИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ



1. Махны экспортыг нэмэгдүүлэхийн тулд төр засгийн байгууллагуудтай хамтран ажиллах.
2. Махны жижиглэн худалдаа руу борлуулалтаа чиглүүлнэ.
  - ❖ Facebook хуудас
  - ❖ Online худалдааг эхлүүлэх
3. Жижиглэн худалдаанд нэр төрлийг нэмэгдүүлэх
4. Дайвар бүтээгдэхүүний жижиглэн худалдааны борлуулалтыг нэмэгдүүлэх
5. Малчдыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн явуулна.



Шинээр худалдаанд  
гаргах 5 төрлийн стейк



Шинээр худалдаанд гаргах  
дайвар бүтээгдэхүүнүүд





# Компанийн хэтийн төлөв



Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын заалт, Засгийн газрын мөн оны 23, 26 дугаар тэмдэглэлийн хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд Нийслэлийн хүн амын хэрэгцээнд 2020-2021 онд худалдан борлуулах хонь, ямаа, үхрийн махыг нөөцөнд бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

# Цаашдын зорилт



Өнөөдөр манай компани мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын орчин үеийн шинжлэх ухаан технологийн дэвшлээс хоцрохгүйн тулд компанийн цаашдын бодлогыг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлж байна.



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА